| D09 | 2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл | 500,863,282.38                  | 630,641,841.59        | 785,508,822.29    | 1,917,013,946.26                       |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код    | Үзүүлэлт  | Төлөвлөгөө           | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|--------|---|----------------------|-----------------------------|
| II     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                  | <b>1,182,940,400</b> | <b>1,180,562,345.94</b>     |
| 21     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                      | <b>1,182,940,400</b> | <b>1,180,562,345.94</b>     |
| 210    | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                    | <b>1,181,985,300</b> | <b>1,179,607,345.94</b>     |
| 2101   | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                  | <b>879,800,800</b>   | <b>878,919,983.77</b>       |
| 210101 | Үндсэн цалин  | 588,394,800          | 588,380,440.06              |
| 210102 | Нэмэгдэл  | 285,946,000          | 268,691,259.85              |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт                                     | 2,340,000            | 8,381,934.96                |
| 210104 | Урамшуулал  | 3,120,000            | 13,466,348.90               |
| 2102   | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>     | <b>28,577,600</b>    | <b>27,080,462.17</b>        |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал                                     | 28,577,600           | 27,080,462.17               |
| 2103   | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>          | <b>107,870,300</b>   | <b>107,870,300</b>          |
| 210301 | Гэрэл, цахилгаан  | 40,723,600           | 40,723,600                  |
| 210302 | Түлш, халаалт   | 54,142,000           | 53,443,700                  |
| 210303 | Цэвэр, бохир ус   | 13,004,700           | 13,703,000                  |
| 2104   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                   | <b>33,094,100</b>    | <b>33,094,100</b>           |
| 210401 | Бичиг хэрэг   | 5,912,600            | 5,912,600                   |
| 210402 | Тээвэр, шатахуун  | 19,490,700           | 19,490,700                  |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 4,175,000            | 4,150,835                   |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 77,800               | 77,800                      |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс               | 3,438,000            | 3,462,165                   |

|             |  |                      |                         |
|-------------|--|----------------------|-------------------------|
| <b>2105</b> | <b>Норматив зардал</b>   | <b>81,970,500</b>    | <b>81,970,500</b>       |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 5,247,800            | 5,247,800               |
| 210502      | Хоол, хүнс   | 76,722,700           | 76,722,700              |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>34,330,600</b>    | <b>34,330,600</b>       |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 6,198,500            | 6,198,500               |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 2,000,000            | 2,000,000               |
| 210604      | Урсгал засвар  | 26,132,100           | 26,132,100              |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>1,351,100</b>     | <b>1,351,100</b>        |
| 210702      | Дотоод албан томилолт  | 1,351,100            | 1,351,100               |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>10,255,000</b>    | <b>10,255,000</b>       |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,841,600            | 5,841,600               |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 420,200              | 420,200                 |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 785,000              | 785,000                 |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 246,200              | 246,200                 |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 466,000              | 466,000                 |
| 210807      | Газрын төлбөр  | 2,496,000            | 2,496,000               |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>4,735,300</b>     | <b>4,735,300</b>        |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 4,462,100            | 4,462,100               |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 273,200              | 273,200                 |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>955,100</b>       | <b>955,000</b>          |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>955,100</b>       | <b>955,000</b>          |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 955,100              | 955,000                 |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>1,182,940,400</b> | <b>1,180,562,345.94</b> |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>1,162,593,800</b> | <b>1,160,215,745.94</b> |
| 310001      | Улсын төсвөөс санхүүжих  | 1,162,593,800        | 1,160,215,745.94        |
| <b>35</b>   | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | <b>20,346,600</b>    | <b>20,346,600</b>       |
| 350002      | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 20,346,600           | 20,346,600              |
| <b>6</b>    | <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>                              | <b>131</b>           | <b>135</b>              |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>  | <b>1</b>             | <b>1</b>                |
| 610001      | Төсвийн байгууллага  | 1                    | 1                       |
| 610002      | Төсвөөс гадуур байгууллага   | 0                    | 0                       |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>  | <b>65</b>            | <b>67</b>               |
| 620001      | Удирдах ажилтан  | 2                    | 2                       |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан  | 61                   | 63                      |
| 620003      | Үйлчлэх ажилтан  | 2                    | 2                       |
| <b>65</b>   | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>   | <b>65</b>            | <b>67</b>               |
| 650002      | Төрийн тусгай албан хаагч (ТТ)                                       | 64                   | 67                      |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он           | Гүйцэтгэл          |
|-------------|--|--------------------|--------------------|
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл |                    |                    |
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>         | <b>65631000.00</b> | <b>46187848.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                             | <b>65631000.00</b> | <b>46187848.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>           | 65631000           | 45187848           |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>          | 8131000            | 1900000            |
| 210402      | Тээвэр, шатахуун                                 | 8131000            | 1900000            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>         | 38931691           | 40287848           |

|             |   |          |            |
|-------------|---|----------|------------|
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 1000000  | 16925000   |
| 210604      | Урсгал засвар   | 37931691 | 23362848   |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | 18568309 | 3000000    |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 18568309 | 3000000    |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   |          | 1000000    |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   |          | 1000000    |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал   |          | 1000000    |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | 79030000 | 46871848   |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 79030000 | 46871848   |
| 131103      | ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 79030000 | 46871848   |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>   |          |            |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  |          | 4117056.19 |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл   |          | 500000     |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн хэмжээнд 2022 онд “Мэдлэг ур чадвараа хөгжүүлэн техник технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, ногоон хөгжлийг дэмжих” зорилт ажиллаж байна.

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 67 алба хаагч, Харуул хамгаалалт, Иргэний шийдвэр гүйцэтгэл, Хорихоос өөр төрлийн шийдвэр гүйцэтгэл, Эмнэлэг, Санхүү аж ахуй гэсэн 5 алба тасаг, нэгжтэй үйл ажиллагаа явуулдаг.

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын 2020-2050 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Алсын хараа -2050, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлиг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2022 оны зорилт “Цахимжуулалт, шинэ сэргэлт”-ийн жил болгох зорилтын хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөж, нарийвчлан тусгасан 22 ажил үйлчилгээ хэрэгжүүлэхээр төлөвлөж8 төлөвлөсөн ажил үйлчилгээний биелэлт 95,2%-тай дүгнэгдсэн.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ховд аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2022 онд ялтны нэрийн данс үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 457-р хорих ангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2022 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1496.9 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 22.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17.9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/сая. төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт     |
|--|----------------|-----------------|--------------|
| Б  | 1              | 2               | 3=2-1        |
| Мөнгө  | 4.1            | 0.5             | 3.6          |
| Авлага                                       |                | 0.8             | 0.8          |
| Бараа материал                               | 172.6          | 137.1           | 35.5         |
| Үндсэн хөрөнгө                               | 1725.1         | 1889.7          | 164.6        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>1901.7</b>  | <b>2028.1</b>   | <b>126.4</b> |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 1883.8         | 1917.8          | 34.0         |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>1901.7</b>  | <b>2028.1</b>   | <b>126.4</b> |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Байгууллагын ялтны нэрийн дансанд 0.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө оны эцэст үлдэж тайлагнасан байна.
- ✓ Авлагын дансанд орон нутгаас үндсэн хөрөнгө худалдан авсны барьцаа хөрөнгийн 5 хувь буюу 0.8 сая төгрөгийг үлдээн авлагаар бүртгэсэн бөгөөд дараа онд бүрэн барагдах боломжтой авлага байна.
- ✓ Бараа материал данс 35.5 сая төгрөгөөр буурахад ШШГЕГ-ын даргын А/273 тоот тушаалаар хөрөнгө акталсан, малын зүй бус хорогдол нөлөөлөл үзүүлсэн байна.
- ✓ Үндсэн хөрөнгө данс 164.6 сая төгрөгөөр өсөхөд Төрийн өмчийн хорооны 626 тоот тогтоолоор газар, 393 тоот тогтоолоор автомашин шилжүүлэн авсан нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

ШШГГ-ын 457-р хорих анги нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвийн санхүүжилтээр 1160.1 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 20.3 сая төгрөг 1.5 сая төгрөгийг жижиг мөнгөн сангаас нийт 1180.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1180.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

ШШГЕГ-аас тус байгууллагын төсвийг улсын төсвөөс 1160.1 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 20.3 сая төгрөг, 1.5 сая төгрөгийг жижиг мөнгөн сангаас 1180.4 сая төгрөг батлан ирүүлжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1182.9 сая төгрөгийн төсөв баталснаас 1162.6 сая төгрөгийг улсын төсвөөс 20.3 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 1.5 сая төгрөгийг жижиг мөнгөн сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

ШШГЕГазарт 2022 оны 9 сард Төсвийн зарлагын хуваарьт бараа үйлчилгээний бусад зардал 2.5 сая төгрөгөөр нэмж батлуулах санал хүргүүлж төсвийн тодотголоор төсвийн санхүүжилтийг 1162.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 20.3 сая төгрөг нийт 1182.9 сая төгрөгөөр баталуулсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1180.6 сая төгрөг буюу 99.7 хувийг зарцуулж 3.1 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

|                                   |  | /сая. төгрөгөөр/ |               |       |             |
|-----------------------------------|--|------------------|---------------|-------|-------------|
| д/д                               | Хөтөлбөр, арга хэмжээ                        | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл     | Зөрүү | Биелэлт     |
| 70705 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэл |  |                  |               |       |             |
| 1                                 | 70705 /80101-Үндсэн үйл ажиллагааны зардал   | 1155.2           | 1153.9        | 3.1   | 99          |
| 2                                 | 70705 /80102- Туслах үйл ажиллагааны зардал/ | 20.3             | 20.3          |       | 100         |
| 3                                 | 70705 /80229-Шийдвэр гүйцэтгэх үйлчилгээ/    | 6.4              | 6.4           | -     | 100         |
| <b>ДҮН</b>                        |  | <b>1182.9</b>    | <b>1180.6</b> |       | <b>99.0</b> |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр Ховд аймгийн Хөшөөт хөгжил сангаас 16.6 сая, Орон нутгийн хөгжлийн сангаас 23.8 сая, Ховд аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 3.3 сая, Ховд аймгийн Онцгой байдлын газраас 3.5 сая нийт 46.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч 46.1 сая төгрөгийг зарцуулж 0.6 сая төгрөгийг татуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул, гэрээт аудитор М.Энхжаргал нар 2022 оны 02 дугаар сарын 06-ноос 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 01/169 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал** Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2022 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1496.9 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 22.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17.9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар нь холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаагүй байна.

3.1-д заасан байр албан томилолтоор ажилласан албан хаагчид тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг давхардуулан олгосон байх гэсэн заалтыг зөрчиж 3.2 сая төгрөгийн буудлын төлбөр төлсөн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 165 мэдээллээс хугацаандаа оруулсан 154 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 11 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Хууль журмын дагуу норм нормативыг баримталж ажиллах эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх гэсэн 1 зөвлөмж өгч хэрэгжилтийг ханган ажилласан байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн алдаа<sup>1</sup>, илэрч залруулга хийлээ.

Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Төсвөөс худалдан авсан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүйтэй холбоотой 0.7 сая төгрөгийг залруулж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 3.7 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, зөрчлийг арилгуулах 3.7 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө хүргүүлсэн.

Харин цаашид засаж сайжруулах шаардлагатай нийт 3.7 сая төгрөгийн зөрчил<sup>3</sup> илэрснээс, 2 зөвлөмж өгсөн.

## 5.2 Зөвлөмж

### 5.2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн байр хоолны зардлыг төсвийн тодотголоор нэмж тусган төлж төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтын хэрэгжилт хангагдаагүй.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах

### 5.2.2 Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Байгууллагын дарга 2022 оны 11 дүгээр сард солигдож шинээр томилогдсон даргын гарын үсгээр баталгаажуулаагүй 0.5 сая төгрөгийн хоорондын тооцоогоор үүссэн гүйлгээг 2022.12.26-ны өдөр хийсэн байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл /сая.төгрөгөөр/

| Алдааны товч утга     | Нийт алдаа |            | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |          | Буруу тусган илэрхийлсэн |            | Үүнээс     |            |
|-----------------------|------------|------------|-----------------------------------|----------|--------------------------|------------|------------|------------|
|                       | Тоо        | Дүн        | Тоо                               | Дүн      | Тоо                      | Дүн        | Залруулсан |            |
|                       |            |            |                                   |          |                          |            | Тоо        | Дүн        |
| элэгдэл дутуу тооцсон | 1          | 0.7        | -                                 | -        | 1                        | 0.7        | 1          | 0.7        |
| <b>Дүн</b>            | <b>1</b>   | <b>0.7</b> | <b>-</b>                          | <b>-</b> | <b>1</b>                 | <b>0.7</b> | <b>1</b>   | <b>0.7</b> |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /сая.төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Үүнээс     |            |               |     |          |            |
|--|------------|------------|---------------|-----|----------|------------|
|  | Нийт алдаа |            | Төлбөрийн акт |     | Зөвлөмж  |            |
|  | Тоо        | Дүн        | Тоо           | Дүн | Тоо      | Дүн        |
| Анхан шатны баримт бүрдэлт хангалтгүй . Гарын үсгээр баталгаажаагүй гүйлгээ хийсэн | 1          | 0.5        |               |     | 1        | 0.5        |
| <b>Дүн</b>   | <b>1</b>   | <b>0.5</b> |               |     | <b>1</b> | <b>0.5</b> |

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая. төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |     | Үүнээс  |     |
|--|-------------|-----|---------|-----|
|  |             |     | Зөвлөмж |     |
|  | Тоо         | Дүн | Тоо     | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил   |             |     |         |     |
| Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн байр хоолны зардлыг төсвийн тодотголоор нэмж тусган төлж төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтын хэрэгжилт хангагдаагүй. | 1           | 3.2 | 1       | 3.2 |
| Дүн  | 1           | 3.2 | 1       | 3.2 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:** *[Signature]* **Б.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:** *[Signature]* **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АХЛАХ АУДИТОР** *[Signature]* **Д.НАРАНТУУЛ**

**ГЭРЭЭТ АУДИТОР:** *[Signature]* **М.ЭНХЖАРГАЛ**